

**БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН ТАСГИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ**

2016.06.20

Багахангай

Д/д	Байгууллагын нэр	АГ-ын ажиглалт	АГ-ын зөвлөмж	Биелэлт
1.	Улаанбаатар хотын цагдаагийн газар / харьяа 19 нэгжийн хамт /	<p>Алба хаагчдын ажлын үр дүнгийн олгосон урамшуулалыг 233.634,6 мянган төгрөгөөр илүү тооцон олгосон нь төрийн албаны тухай хуулийн 31,1,2,3 дугаар зүйл, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн шагнал, урамшуулал олгох журам"-д заасан шагналын хэмжээ нь албан тушаалын сарын цалингийн 40 хувьтай тэнцэхээр тогтоосон байна"- гэсэн заалтыг зөрчсөн / төсөв захирагчид өөрсдөө хүлээн зөвшөөрөөгүйгээ менежментийн захидалдаа хүргүүлсэн/</p> <p>Орлого үр дүнгийн тайланд барьцааны мөнгөний 57,117,0 мянган төгрөгийн хөрөнгийг давхардуулан, хөрөнгийн газрыг 430,718.4 мянган төгрөгөөр зөрүүлсэн, батлан хамгаалах зориулалттай тоног төхөөрөмжинд 3,375.0 төгрөгийн элэгдэлийн зардал тооцоогүй, мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан үндсэн хөрөнгийн дүнг тодруулгын тайлангаас 225,276.9 мянган төгрөгөөр, жилийн эцсийн нэгдсэн тайлан 3,593,530.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгийг давхардуулан бүртгэсэн, бараа материалын мал амьтан дансны нас дэвшилтийг зах зээлийн үнээр бүртгэлжүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн.</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт оруулсан "Үндсэн цалин" гэсэн тодорхойлолтыг Хөдөлмөрийн тухай хууль, ЗГ-ийн тогтоол болон бусад холбогдох эрх зүйн актуудтай нийцүүлэх талаар дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.</p> <p>Залруулга хийж цаашид зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн.</p>	<p>Тус цагдаагийн тасаг нь 2015 оны байдлаар алба хаагчдын ажлын үр дүнгийн олгосон урамшуулалыг 242.100 төгрөгөөр илүү тооцон олгосон байсан бөгөөд төрийн албаны тухай хуулийн 31,1,2,3 дугаар зүйл, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн шагнал, урамшуулал олгох журам"-д заасан шагналын хэмжээ нь албан тушаалын сарын цалингийн 40 хувьтай тэнцэхээр тогтоосон байна"- гэсэн заалтыг зөрчсөн зөвлөмжийг Нийслэлийн аудитын газраас өгсөн. Өгсөн зөвлөмжийн дагуу дахин ийм зөрчил дутагдал гаргахгүй байх тал дээр анхааран ажиллаж байгаа бөгөөд эхний хагас жилийн байдлаар алба хаагчдын ажлын үр дүнгийн урамшуулал олгохдоогүй байна.</p> <p>Энэ зөрчил дутагдал тус цагдаагийн тасагт заагдаагүй болно.</p>

		<p>Шийтгэвэр, торгуулийн орлогын 43,655.0 мянган төгрөгийг 4-345 хоногоор хугацаа хоцроон харилцах дансанд тушаасан нь Сангийн сайдын 1992 оны 112 дугаар тушаалаар баталсан Шийтгэвэр торгуулийн хуудас түүнийг хэрэглэх зааварт "Торгууль ногдуулж торгуулийн мөнгийг 3 хоногийн дотор "байгууллагынхаа дансанд / кассд/ тушааж, тухай бүр тооцоо хийнэ заалт зөрчсөн</p>	<p>Төсөвт төвлөрүүлэх орлогыг хууль журамд заагдсан хугацаанд улсын төсөвт төвлөрүүлж байх.</p>	<p>Тус цагдаагийн тасгийн 2015 оны үнэт цаасыг Нийслэлийн аудитын газраас шалгахад шийтгэвэр, торгуулийн орлогын 30.000 төгрөгийг хугацаа хоцроон харилцах дансанд тушаасан зөрчил дутагдал илэрсэн. Энэ зөрчлийг дахин гаргахгүй байгаа бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/71 дүгээр тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Шийтгэвэр, торгуулийн хуудас зэрэг тооцооны хуудсаар хангах, хадгалах, олгох, зарцуулах, тооцох, бүртгэх / код-812 / журам-ын хэрэгжилтийг хангах ажиллаж байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын цагдаагийн газрын санхүүгээс 600 ширхэг буюу 3.000.000 төгрөгний торгуулийн тасалбар, 200 ширхэг шийтгэврийг авч зохих журмын дагуу орлогод аван алба хаагч нарт олгоод бана. 2016 оны 05 дугаар сарын 31-ны байдлаар тус дүүргийн татварын хэлтэсийн 30070001908 дансанд 3.046.000 төгрөг, 30070003466 21.896.780 төгрөг, нийт 24.942.780 төгрөгний хүү торгуулийн орлогыг оруулаад байна. Дүүргийн татварын хэлтэстэй тооцоо нийлж ажиллаж байгаа бөгөөд хүү торгуулийн орлогыг 3.142.780 төгрөгөөр давуулан биелүүлэн зөрчил дутагдал гаргахгүй ажиллаж байна.</p>
--	--	---	---	--

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:НЯГТЛАН БОДОГЧ,ЦАГДААГИЙН ДЭСЛЭГЧ



Б.НАРАНТУЯА